



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/53

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хэрлэн-Улаан тосгоны захирагч С.Баясгаланд холбогдох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч /Д.Цэцэгсүрэн/-ийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2-т заасан эрх, үүргийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч /Д.Цэцэгсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030788